



БОГД СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМ-Д

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2020.07.28 № 124
танай _____ -ны № _____ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.3, 37.5 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох тус сумын Монгол Ардын намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцүүлэн сонгуулийн мөрийн хөтөлбөрөө боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт аймаг дахь Төрийн аудитын байгуулагад ирүүлж, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль 37 дугаар зүйлийн 37.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох сумын Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020”, Өвөрхангай аймгийн нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, “Өвөрхангай аймгийн эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг”, Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

015030643

D:\Auditiiin gazar\baiguullagiin dotood barimt\A4


Дүгнэлт

Сумын Монгол Ардын намын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгууль”-д оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сумын сонгуулийн хороонд

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЛАМААЧИН

Өвөрхангай аймгийн Богд сүмын МАН-ын
тэргүүлэгчдийн 2020 оны 06 сарын 19-ны
20/03 дугаар тогтоолын хавсралт

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СҮМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БОГД СҮМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Өвөрхангай аймгийн нийгэм эдийн засгийг 2014-2024 онд хөгжүүлэх бодлогын баримт бичиг, Богд сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон аймгийн салбаруудын дунд хугацааны хөтөлбөрүүдийг судлан 2020 оны сумын ИТХ-ын сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийг боловсруулан сонгоч танд толилуулж байна.

НЭГ. АЖИЛ ОРЛОГОТОЙ ИРГЭН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Хөдөө аж ахуйн, аж үйлдвэр, аялал жуучлалын салбарыг эрчимтэй хөгжүүлж эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

1.1 Хөгжлийг тэтгэгч- Дэд бүтэц

1.1.1 Сумын цэвэр усны болон ариутгах татуургын нэгдсэн байгууламж, дулааны төвлөрсөн системийг хэвийн үйл ажиллагаагаар хангаж, аж ахуй нэгж, айл өрхийг ёёйгүйд холбогдох нөхцөлийн бүрдүүлнэ.

1.1.2 Зарим багуудыг үүрэн холбооны сүлжээний чанар хүртээмжийг сайжруулах, хамрах хүрээг өргөтгөх зорилтын хүрээнд үүрэн холбооны оператор байгууллагуудад санал тавьж, хамтран ажиллана.

1.2 Хөдөө аж ахуй, хөдөлмөр эрхлэлт

1.2.1 “Малжуулах хөтөлбөр”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, Байгалин гамшиг, ган зудын улмаас малгүй болсон, цөөн малтай малчин болон залуучуудыг төсөл хөтөлбөрт хамруулах

1.2.2 Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, малын эмч мэргэжилтнүүдийн хүрэлцээг хангах замаар мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бус байдлаар нь хадгалах

1.2.3 Бэлчээрийг хашиж хамгаалах, ашиглалтын менежментийг сайжруулах, инженерийн хийцтэй худаг шинээр барих, засварлах, булаг шандны эхийг хамгаалах, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлыг хэрэгжүүлэх

1.2.4 Нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх

1.2.5 Мал аж ахуйн түүхий эдэд түшиглэсэн арьс, шир, ноос, ноолуурыг уламжлалт технологи болон бага оврын тоног төхөөрөмж ашиглан боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг цех байгуулах

1.2.6 Махны чиглэлийн үүлдрийн мал өсгөх бодлогыг дэмжиж, мал нядалгааны цэг байгуулж, малын дотор дайвар бүтээгдэхүүнийг боловсруулж борлуулах жижиг үйлдвэр байгуулж малчдын мах борлуулах орлогыг нэмэгдүүлнэ.

1.3 Байгаль орчин, аялал жуучлал

1.3.1 Сумын байгалийн болон түүх, соёлын дурсгалт газруудыг, олон нийтэд сурталчил, гадаад дотоодын жуулчдыг татах ажлыг зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгжүүдийг аялал жуучлалаас олох орлогыг нэмэгдүүлэх

1.3.2 Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагааг тогтмолжуулан, ган хуурайшилтын эрсдэлийг бууруулах ХОЁР. ИРГЭДЭЭ БОЛОВСРОЛ ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД АДИЛ ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАМРАГДАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛНЭ

2.1 Эрүүл иргэн- Нийгмийн үнэт баялаг

2.1.1 Нийгмийн эрүүл мэндийг тусламж үйлчилгээг эрүүл мэндийн байгууллагуудын тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ

2.1.2. Сумын эрүүл мэндийн төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах, эмч мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, тогтвортой удирдлагаар хангах, багийн эмч нарыг багийн төв дээр ажиллуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх

2.1.3 Эрүүл мэндийн төвийн автомашины парк шинэчлэл хийж, багын эмч унаагаар шат дараалалтайгаар хангаж материаллаг баазыг дээшлүүлэх

2.1.4 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, архины хэрэглээг багасгах, хорт зуршлыг арилгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшил төрийн бус байгууллагыг дэмжиж ажиллана.

2.1.5 Эрүүл мэндийн төвийн шинэ барилга барьж ашиглалтад оруулах.

2.2 Боловсрол төлөвшилт- Хүний үнэт зүйл

2.2.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллын тавилга тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн материаллаг баазыг үе шаттайгаар нэмэгдүүлж багш нарын чадавхыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

2.2.2 Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн шинэ байрны материаллаг баазыг нэмэгдүүлэх, сурагчдын ширээ сандал, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангах, багш ажилчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

2.2.3 Багш боловсон хүчний мэргэжил, боловсрол, ур чадварыг нэмэгдүүлэх, гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, тэдний нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэхэд анхаарах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болго.

2.2.4 Суманд спортын ордон барьж ашиглалтад оруулж иргэд, хүүхэд багачуудыг спортоор тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлнэ.

2.3 Гэр бүлийн хөгжил- Нийгмийн хамгаалал

2.3.1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, төр, иргэний нийгмийн байгууллагын хамтарсан сүлжээг бий болгон, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах

2.3.2 Залуучуудыг амьдралын зөв дадалд сургах, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалт амралт, чөлөөт цагийн чиглэл бүхий залуучуудын хөгжлийн төвийг байгуулах

3

2.3.3 Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, тэдний амьдралын туршлага, мэдлэг чадварыг залуу үеийнхэнд өвлүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, суманд ахмадуудад зориулсан Ахмадын өргөтэй болох

ГУРАВ. ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэдийн оролцоотой төрийн үйлчилгээг төрөөс иргэдэд шуурхай, хүртээмжтэй, шударга, ялгамжгүй үйлчилдэг тогтолцоог бий болгоно.

3.1 Төрийн үйлчилгээ иргэн танд

3.1.1 Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөхдөө иргэдийн саналыг үндэслэн хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах

3.1.2 Төрийн албан хаагчийн цалинг иргэдэд үзүүлсэн ажлын бүтээмж үйлчилгээний чанартай нь уялдуулж олгодог зарчим нэвтрүүлж, ажлын цаг ашиглалтын хяналтыг цахим хэлбэрт шилжүүлж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.

3.1.3 Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай тэгш хүртээмжтэй хүргэх, Иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор сумын ЗДТГ-ын барилгыг шинээр бариж ашиглалтанд оруулах

3.1.4 Төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, шуурхай болгоход чиглэсэн шинэ дэвшилтэт хэлбэрийн үйлчилгээг тууштай нэвтрүүлж, төрийн албаны хяналтын сүлжээг бий болгож, төрийн байгууллагуудыг салбар дундын цахим сүлжээнд бүрэн нэгтгэж, иргэдийн тавьсан асуудлыг шуурхай шийдвэрлэдэг болгох

3.1.5 Иргэд олон нийтийн оролцоотойгоор газар зохион байгуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагааг нээлттэй ил тодоор хэрэгжүүлэх

3.2 Хууль эрх зүй, аюулгүй амьдрал

3.2.1 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөө орон нутгийн авто замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулж, сумын 1.5 км замыг засмал болгох

3.2.2 Засгийн газар болон аймгийн ИТХ-аас батлагдсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажиллах

3.2.3 Цагдаагийн тасгийн шинэ байр барьж ашиглалтад оруулах, Цагдаагийн албан хаагчдыг тээврийн хэрэгслээр хангах

3.2.4 Гэмт хэрэг үйлдэгдэх гол шалтгаан болсон архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, амьдралын буруу зуршил зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүдтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, дэлхий нийтийн үнэт зүйл, Монгол ёс зан заншил ухамсыг хүүхэд залуучуудад төлөвшүүлэн зөв хүмүүжил олгох ажлыг иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоотой хэрэгжүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО

